

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/119/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум
2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Нью-баланс аудит ХХК-ийн партнер Б.Лхагвадорж
Утас: 99101901 Цахим хаяг: newbalance.lhagvaa@gmail.com
Аудитор: Д.Гэрэлчулуун
Утас: 99509636 Цахим хаяг: d.gerlee98@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА	
НЬЮ-БАЛАНС АУДИТ ХХК.....	1
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцолсон хэсэг	4
Аудитын гол асуудал	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 01/214
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН БАЯНЗҮРХ
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ Ч.
ДЭЛГЭРМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээллийг оруулна.

2022 онд хувьсах зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн ба улсын төсвөөс 356,405.3 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 84,816.4 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 40,887.2 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 1,999.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлууд байна. Засаглах эрх бүхий этгээдийн түвшин дэх харилцаанаас аудитын гол асуудлыг сонгоно.

Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, 2022 оноос санхүүгийн хувьд үр дүн, чанар гүйцэтгэлд нь үндэслэн санхүүжүүлэх, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлын санхүүжилт, суралцагчийн сургалтын чанарыг үнэлэх хараат бус тогтолцоо, багшийн ажлын үр дүнг сургалцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого зэргийг багцаар нь шийдвэрлэхээр хууль эрх зүйн актад өөрчлөлт оруулж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг ч үр дүнд суурилсан байдлаар хэрэгжүүлэхийг зорьсон байна.

Бусад асуудлын хэсэг

Бусад асуудлын хэсэгт аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай

хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудлыг оруулна.

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь *Баянзүрх сумын Засаг даргатай* 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө хийж, түүнийг 78 хувь биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	84,969,604.59	171,548,096.93
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	84,816,497.34
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	84,816,497.34
3121	Төгрөг	00.00	84,816,497.34
31211	Төрийн сангийн харилцах	84,969,604.59	86,731,599.59
35	БАРАА МАТЕРИАЛ	16,120,228.00	13,829,468.00
351	Түүхий эд материал	12,276,118.00	12,731,118.00
35110	Тусгай зориулалттай материал	3,844,110.00	1,098,350.00
35130	Эм боох материал	68,849,376.59	72,902,131.59
354	Хангамжийн материал	3,236,450.00	2,856,250.00
35410	Бичиг хэргийн материал	31,898,616.59	35,983,616.59
35420	Аж ахуйн материал	13,875,000.00	9,860,580.00
35440	Түлш, шатах тослох материал	2,632,800.00	5,167,800.00
35450	Барилгын засварын материал	13,684,610.00	17,377,285.00
35460	Хүнсний материал	3,521,900.00	1,656,600.00
35470	Бусад хангамжийн материал	218,562,805.43	224,080,510.28
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	218,562,805.43	224,080,510.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	210,566,805.43	216,282,010.36
392	Биет хөрөнгө	199,457,263.95	199,457,263.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	-42,342,801.34	-51,002,920.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	44,460,792.00	64,610,317.80
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-10,473,466.61	-20,196,163.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	20,623,188.50	22,067,193.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-5,605,176.36	-8,790,868.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	19,308,863.26	27,550,681.26
39214	Бусад үндсэн хөрөнгө	-16,294,112.97	-18,845,749.44
39215	Хуримтлагдсан элэгдэл	1,432,255.00	1,432,255.00
39217	Ном	7,996,000.00	7,798,499.92
393	Биет бус хөрөнгө	900,000.00	900,000.00
39301	Програм хангамж	00.00	-197,500.08
39302	Хуримтлагдсан элэгдэл	7,096,000.00	7,096,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	303,532,410.02	395,628,607.21
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	00.00	2,479,830.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,479,830.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,479,830.00
413	Өглөг	00.00	2,479,830.00
4136	Бусад өглөг	00.00	2,479,830.00
41361	Байгууллагад төлөх өглөг	303,532,410.02	393,148,777.21
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		

51	Засгийн газрын хувь оролцоо	303,532,410.02	393,148,777.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	97,878,361.33	97,878,361.33
51101	Өмч: - төрийн	97,878,361.33	97,878,361.33
512	Хуримтлагдсан үр дүн	139,754,639.10	229,371,006.29
51210	Өмнөх үеийн үр дүн	139,754,639.10	139,754,639.10
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	89,616,367.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	65,899,409.59	65,899,409.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	303,532,410.02	395,628,607.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	332,232,533.50	429,582,896.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,496,400.50	32,290,348.80
120	Нийтлэг татварын бус орлого	14,496,400.50	32,290,348.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,496,400.50	32,290,348.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	947,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,549,400.50	32,290,348.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	24,992,733.00	397,292,547.54
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	356,405,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	356,405,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	292,743,400.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	174,533.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	174,533.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,818,200.00	39,466,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,818,200.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	297,309,121.39	339,966,529.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	297,309,121.39	339,966,529.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	274,197,561.41	337,966,829.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194,686,132.00	218,187,993.18
210101	Үндсэн цалин	124,675,693.00	153,656,885.14
210102	Нэмэгдэл	55,789,936.00	34,652,380.75
210104	Урамшуулал	14,220,503.00	29,878,727.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,494,305.00	27,092,610.48
210201	Тэтгэврийн даатгал	17,012,630.87	18,563,899.31
210202	Тэтгэмжийн даатгал	1,614,282.77	2,134,931.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,497,244.14	1,707,945.54
210204	Ажилгүйдлийн даатгал	627,036.78	500,404.74
210205	Эрүүл мэндийн даатгал	3,743,110.44	4,185,429.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол	9,699,386.02	18,150,730.54

	зардал		
210301	Гэрэл, цахилгаан	1,450,736.02	3,258,525.54
210302	Түлш, халаалт	7,953,000.00	13,869,200.00
210303	Цэвэр, бохир ус	295,650.00	1,023,005.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,902,878.55	11,030,386.00
210401	Бичиг хэрэг	330,600.00	4,415,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,502,350.00	2,974,486.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,530,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,754,117.00	3,640,100.00
210408	Бараа материал акталсны зардал	5,785,811.55	00.00
2105	Нормативт зардал	10,962,180.00	34,437,465.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,153,590.00	2,745,760.00
210502	Хоол, хүнс	9,808,590.00	31,691,705.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	540,000.00
210604	Урсгал засвар	00.00	540,000.00
2107	Томилолт, зочны зардал	182,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	182,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	660,000.00	935,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	925,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	10,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,610,679.84	27,592,643.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	278,000.00	3,275,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,704,800.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,627,879.84	24,317,643.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,111,559.98	578,952.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,852,096.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,852,096.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,259,463.98	578,952.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,259,463.98	578,952.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	34,923,412.11	89,616,367.19
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	689,616.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	689,616.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-689,616.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	34,233,796.11	89,616,367.19

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	318,683,133.00	395,292,847.54
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	947,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	947,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	947,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	947,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	317,736,133.00	395,292,847.54
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	356,405,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	356,405,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	292,743,400.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	174,533.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	174,533.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,818,200.00	39,466,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,818,200.00	39,466,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	294,330,033.00	310,476,350.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	294,330,033.00	310,476,350.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	271,218,473.02	310,476,350.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194,686,132.00	218,187,993.18
210101	Үндсэн цалин	124,675,693.00	157,092,880.37
210102	Нэмэгдэл	55,789,936.00	36,568,881.81
210104	Урамшуулал	14,220,503.00	24,526,231.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,494,305.00	27,092,610.48
210201	Тэтгэврийн даатгал	17,012,630.87	18,420,046.73
210202	Тэтгэмжийн даатгал	1,871,555.22	2,171,030.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,497,244.14	1,736,824.54
210204	Ажилгүйдлийн даатгал	369,764.33	397,707.35
210205	Эрүүл мэндийн даатгал	3,743,110.44	4,367,001.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,748,736.02	14,421,366.54
210301	Гэрэл, цахилгаан	1,450,736.02	3,258,525.54
210302	Түлш, халаалт	18,000,000.00	9,854,780.00
210303	Цэвэр, бохир ус	298,000.00	1,308,061.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,982,400.00	00.00
210401	Бичиг хэрэг	1,229,300.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,530,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	100.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,723,000.00	00.00
2105	Нормативт зардал	15,465,900.00	35,384,380.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,076,400.00	00.00

210502	Хоол, хүнс	13,389,500.00	35,384,380.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,948,000.00	3,000,000.00
210602	Тавилга	1,838,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,110,000.00	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	182,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	182,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	660,000.00	925,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	925,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,051,000.00	11,465,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,273,200.00	9,965,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,777,800.00	1,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,111,559.98	578,952.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,852,096.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,852,096.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,259,463.98	578,952.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,259,463.98	578,952.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	24,353,100.00	84,816,497.34
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	24,353,100.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,353,100.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	24,353,100.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	24,353,100.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-24,353,100.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	84,816,497.34
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	84,816,497.34

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
С01	2020 оны 12-р сарын 31-нээрх	97,878,361.33	66,025,109.59	83,342,804.42	247,246,275.34

	үлдэгдэл				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	97,878,361.33	66,025,109.59	83,342,804.42	247,246,275.34
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-5,321,547.64	-5,321,547.64
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	97,878,361.33	65,899,409.59	139,754,639.10	303,532,410.02
D01	2022 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	97,878,361.33	65,899,409.59	139,754,639.10	303,532,410.02
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	97,878,361.33	65,899,409.59	139,754,639.10	303,532,410.02
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	89,616,367.19	89,616,367.19
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	97,878,361.33	65,899,409.59	229,371,006.29	393,148,777.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

эдийн засгийн ангилал	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	395,871,800.00	310,476,350.20	85,395,449.80	78.40
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	395,871,800.00	310,476,350.20	85,395,449.80	78.40
210	Бараа, үйлчилгээний зардал	395,871,800.00	310,476,350.20	85,395,449.80	78.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	293,375,000.00	218,187,993.18	75,187,006.82	74.37
210101	Үндсэн цалин	241,754,300.00	157,092,880.37	84,661,419.63	64.98
210102	Нэмэгдэл	47,143,100.00	36,568,881.81	10,574,218.19	77.57
210104	Урамшуулал	4,477,600.00	24,526,231.00	(20,048,631.00)	547.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,570,000.00	27,092,610.48	9,477,389.52	74.08
210201	Тэтгэврийн даатгал	24,910,100.00	18,420,046.73	6,490,053.27	73.95
210202	Тэтгэмжийн даатгал	2,930,600.00	2,171,030.76	759,569.24	74.08
210203	ҮОМШӨ ний даатгал	2,344,500.00	1,736,824.54	607,675.46	74.08
210204	Ажилгүйдлийн даатгал	586,100.00	397,707.35	188,392.65	67.86
210205	Эрүүл мэндийн даатгал	5,798,700.00	4,367,001.10	1,431,698.90	75.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,042,500.00	14,421,366.54	621,133.46	94.83
210301	Гэрэл цахилгаан	3,500,000.00	3,258,525.54	241,474.46	93.10
210302	Түлш, халаалт	10,000,000.00	9,854,780.00	145,220.00	98.55

210303	Цэвэр, бохир ус	1,542,500.00	1,308,061.00	399,186.54	76.62
2105	Нормативт зардал	35,404,300.00	35,384,380.00	19,920.00	99.94
210502	Хоол, хүнс	35,404,300.00	35,384,380.00	19,920.00	99.94
2106	Эд хогшил худалдан авах	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	962,000.00	925,000.00	37,000.00	96.15
210806	Мэдээллийн технологийн зардал	962,000.00	925,000.00	37,000.00	96.15
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	11,518,000.00	11,465,000.00	53,000.00	99.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,018,000.00	9,965,000.00	53,000.00	99.47
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	395,871,800.00	395,292,847.54	578,952.46	99.85
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	356,405,300.00	356,405,300.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	356,405,300.00	356,405,300.00	-	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39,466,500.00	38,887,547.54	578,952.46	98.53
132001	Орон нутгийн төсвөөс	39,466,500.00	38,887,547.54	578,952.46	98.53
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	84,816,497.34	(84,816,497.34)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	16.00	16.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар орлого хүлээн аваагүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэг нь тухайн орон нутагт сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг эрхэлж байна. Тус хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд "Хүүхдийн хөгжлийг бүх талаар дэмжиж, сурах үйлийг дадал болгох сургалтын олон талт шинэлэг аргаар үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах" гэсэн зорилго тавьж, тус зорилгын хүрээнд 4 зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь Баянзүрх сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө хийж, түүнийг 78 хувь биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна. Засгийн газар болон Боловсрол шинжлэх ухааны яамнаас дараах шийдвэрүүдийг гаргасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:

1. Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр”, “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал” баталсан байна.
2. Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ” баталсан байна.
3. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/259 дүгээр тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар”-ыг баталсан байна.
4. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дүгээр тушаалаар “төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ыг 1 дүгээр, “багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ыг 2 дугаар, “цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг 3 дугаар, “тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус батлан хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу цэцэрлэгийн эрхлэгчийн 2022 оны 09 сарын 09 өдрийн А/45 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна. Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 6 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсролын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Боловсролын яам, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 92,096.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	84,816.50	84,816.50
Бараа материал	84,969.60	86,731.60	1,762.00
Үндсэн хөрөнгө	218,562.80	224,080.50	5,517.70
Нийт хөрөнгө	303,532.40	395,628.60	92,096.20
Өр төлбөр	0	2,479.80	2,479.80
Засгийн газрын хувь оролцоо /Төрийн өмч/	97,878.40	97,878.40	0.00
Хуримтлагдсан үр дүн	139,754.60	229,371.0	89,616.40
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	65,899.40	65,899.40	0.00
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	303,532.40	395,628.60	92,096.20

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 84,816.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 1,762.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хүүхдийн хоолны материалын үлдэгдэл гол нөлөөг үзүүлсэн байна.
3. Үндсэн хөрөнгө данс 5,517.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 29,835.3 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 24,317.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 452,791.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 29,620.0 мянган төгрөг, нийт 482,411.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэх дүнг 96,386.3 мянган төгрөгөөр бууруулж, орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх дүнг 5,267.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь орон нутгийн төсвөөс авах дүн нэмэгдсэн нь байгууллагын төрийн үйлчилгээний ажилчид цалин авах болсонтой холбоотой, улсын төсвөөс авах дүнг их хэмжээгээр бууруулсан нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Байгууллагын 2022 оны төсвийн сар, улирлын хуваарийг Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаалаар баталж ирүүлсэн ба тайлант онд төрийн үйлчилгээний ажилчид орон нутгийн төсвөөс улсын төсөвт шилжсэнтэй, мөн өргөн хэрэглээний бараа материалын үнэ өссөнтэй холбоотой Боловсрол Шинжлэх ухааны сайдын тушаалаар төсөвт 1 удаа зохицуулалт хийгдэж төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулсан байна.

Тус цэцэрлэг нь 2022 онд 150 хүүхдийн хүчин чадалтай ажиллаж нэг хүүхдийн нормоор тооцож авах санхүүжилт 333,419,3 мянган төгрөг байх байтал 356,405.3 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Тайлант онд 22,986.1 мянган төгрөгийн илүү санхүүжилт авсан нь төлөвлөлт үндэслэл муутай төлөвлөгдсөн байна.

Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, 2022 оноос санхүүгийн хувьд үр дүн, чанар гүйцэтгэлд нь үндэслэн санхүүжүүлэх, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлын санхүүжилт, суралцагчийн сургалтын чанарыг үнэлэх хараат бус тогтолцоо, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого зэргийг багцаар нь шийдвэрлэхээр хууль эрх зүйн актад өөрчлөлт оруулж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг ч үр дүнд суурилсан байдлаар хэрэгжүүлэхийг зорьсон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан орон нутгийн төсвийг 6,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 356,405.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 39,466.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 356,405.3 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч батлагдсан төсвийн дагуу зарцуулж, 84,816.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 39,466.5 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 578.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 310,476.3 мянган төгрөг буюу 78.4 хувьтай байгаа нь боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын төсвийг 84,541.8 мянган төгрөгөөр, ТШЗ-ийн байгууллагуудын тогтмол зардлын төсвийг 578.6 мянган төгрөгөөр, Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардлын төсвийг 254.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
1	ТШЗ-ийн байгууллагуудын тогтмол зардал	18,000.00	17,421.37	578.63	96.80%
2	Нийтлэг үйлчилгээ	21,466.50	21,466.18	0.32	100%
3	Эрүүл мэндийн үйлчилгээ	1,300.00	1,300.00	0.00	100%
4	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	35,404.30	35,384.38	19.92	99.90%
5	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,085.20	2,085.00	0.20	100%
6	Багшийн тасралтгүй хөгжил	1,300.00	1,300.00	0.00	100%
7	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	287,206.10	202,664.28	84,541.82	70.56%
8	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	29,109.70	28,855.14	254.56	99.10%
	Нийт дүн	395,871.80	310,476.35	85,395.45	78.40%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус Хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого хүлээн аваагүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ньюбаланс аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Гэрэлчулуун гүйцэтгэж, хяналтыг Ньюбаланс аудит ХХК-ийн захирал Б.Лхагвадорж анхан шатанд хянаж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ньюбаланс аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 297,309.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6,644.6 мянган төгрөгөөр, мөн санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын (80 хувиар) буюу 5,315.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томиллолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй зүйл илэрсэн болно. Үүнд: Тайлант онд бараа үйлчилгээний бусад зардлаас 500.0 мянган төгрөгөөр ажилчдын хүүхдүүдэд бэлэг өгсөн байгаа нь Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дах заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. 2022 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт нийт 148 мэдээлэл оруулахаас 85 мэдээлэл хугацаа хоцорч мэдээлсэн, 61 мэдээлэл хугацаандаа мэдээлж, 2 мэдээллийг оруулах хугацаа болоогүй байна.
2. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад орлогын 341,304.4 мянган төгрөгийн 20 гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, дахь заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2019 оны 450 дугаар "Хоолны зардлын норматив тогтоох тухай" тогтоолын хэрэгжилтийг хянаж үзэхэд дараах зөрчилтэй асуудал илэрч байна. Үүнд:

1. Хүүхдийн хоолны зардлыг Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор баталсан норм, нормативын дагуу тооцож олгосон эсэхийг дахин хянахад 2022 онд 1,850.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зөрчил илэрч байна. Энэ нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.11 дэх заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн

2. Бараа үйлчилгээний бусад зардлаас тээвэр шатахууны зардалд 3,997.4 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас цалингийн зардалд 1,728.2 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна..

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

		/мянган төгрөгөөр/
Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт	Биелэлт

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	3	0.0	2	0.0	50
Нийт дүн	3	0	21	0	50

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хүнсний өргөн хэрэглээний бараа материалын үнэ өссөн нь хүүхдийн хоолны норм, норматив хэтрэх эрсдэлтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлангийн толилуулгыг илэрхийлэхдээ нягтлан бодох бүртгэлээс зөрүүтэй илэрхийлсэн байсныг аудитын хугацаанд залруулсан болно.

Аудитаар нийт 357,509.0 мянган төгрөгийн алдаа¹, зөрчил² илрүүлж, аудитын явцад 8,128.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 500.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 341,304.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 7,576.5 мянган төгрөгийн зөрчилд дахин давтахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Залруулга

- Бараа үйлчилгээний бусад зардлаас шилжүүлсэн 445.5 мянган төгрөгийн гүйлгээний зардлын ангилалыг үндсэн цалин гэж андуурч бүртгэснийг залруулсан.
- Орлогыг 1,999.7 мянган төгрөгөөр бууруулж тайлагнасныг залруулсан.
- Үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого нь үндсэн хөрөнгө ба бараа материалын тодруулга тайлангийн үнэ төлбөргүй болон хандиваар хүлээн авсан дүнгээс 5,682.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд эрхлэгчийн тушаалаар бараа үйлчилгээний бусад зардлаас ажилчдын хүүхдүүдэд 500.0 мянган төгрөгийн бэлэг өгсөн нь Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дах заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Албан шаардлага

Тус цэцэрлэг нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар зөвлөмж авсан мөн тайлант онд 85 мэдээлэл хугацаа хоцорч мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад орлогын 341,304.4 мянган төгрөгийн 20 гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хүүхдийн хоолны зардлыг Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор баталсан норм, нормативын дагуу тооцож олгосон эсэхийг дахин хянахад 2022 онд 1,850.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зөрчил илэрч байна. Энэ нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.11 дэх заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хүүхдийн хоолны норм, нормативыг баримтлан ажиллах

Илрүүлэлт:

Бараа үйлчилгээний бусад зардлаас тээвэр шатахууны зардалд 3,997.4 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас цалингийн зардалд 1,728.2 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бүртгэлийн алдаа залруулсан	3	8,128.1	0	0	0	0	3	8,128.1	0	0	0	0
Дүн	3	8,128.1					3	8,128.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Батлагдсан төсвийг зориулалтаар нь зарцуулаагүй	2	5,725.7	0	0	0	0	2	5,725.7		0	0	0
									0	0	0	0
Дүн	2	5,725.7	0	0	0	0	2	5,725.7	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцроож мэдээлсэн	85	0	0	0	1	341,304.4	0	0
Мэдээлээгүй	20	341,304.4						0
Дүн	105	341,304.4			1	341,304.4	0	0
Норм норматив баримтлаагүй	1	1,850.6					1	1,850.6
Төсвийн хөрөнгөөр бэлэг өгсөн	1	500.0	1	500.0				
Дүн	2	2,350.6	1	500.0			1	1,850.6
Нийт дүн	107	343,655.0	1	500.0	1	341,304.4	1	1,850.6

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ ПАРТНЕР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО: 20/24

Л.МАНДАХНАРАН ОГНОО: 11/24

Б.ЛХАГВАДОРЖ ОГНОО: 2023.02.23



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

᠒᠐᠒3 оны ᠐᠒ сарын 1᠖ өдөр

№ ᠐5/᠒᠐᠒3᠐439/ХӨА-᠒᠐᠒3/119
/НА-СТА-ТНЗ

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 148 мэдээлэл оруулахаас 85 мэдээлэл хугацаа хоцорсон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 20 гүйлгээг мэдээлээгүй 341,304,481.00 (гурван зуун дөчин нэгэн сая гурван зуун дөрвөн мянга дөрвөн зуун наян нэг) төгрөгийн 20 мэдээллийг мэдээлээгүй байна.
2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын 4.2.1.10-т “Аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй”, 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно” гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2023 оны 9 дугаар сарын 01-ний дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Ч.Дэлгэрмаа, нягтлан бодогч Б.Хишигжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  А.ЭРДЭНЭБААТАР
АУДИТОР:  Д.ГЭРЭЛЧУЛУУН

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043